



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 454

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5, 6.4, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2022 оны 6 дугаар сарын 29-ны 17-07-037-93, 6 дугаар сарын 27-ны 17-07-037-91 дугаар актаар тогтоогдсон 2,776,180.00 (хоёр сая долоон зуун далан зургаан мянга нэг зуун наян) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар, 9 нэрийн, нийт 8,031,411.03 (найман сая гучин нэгэн мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Т.Наран-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003183
24-T_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТЛАЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Улаан булан /барилга/	1971-12-26	1	2,387,120.00	2,387,120.00
2	Туулайн байр	1984-05-26	1	389,060.00	389,060.00
ДҮН			2	2,776,180.00	2,776,180.00 (хоёр сая долоон зуун далан зургаан мянга нэг зуун наян)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Мотоцикл	1995-05-26	1	528,000.00	528,000.00
2	Тоос сорогч	2011-06-23	1	129,990.00	129,990.00
3	Компьютер at	2014-04-11	1	482,813.15	482,813.15
4	Компьютер 2016	2016-01-01	2	805,000.00	1,610,000.00
5	Тог баригч UPS	2014-04-11	1	136,550.86	136,550.86
6	Зөөврийн ком lenowa	2016-01-01	2	560,000.00	1,120,000.00
7	Принтер samsung	2014-04-11	1	351,129.02	351,129.02
8	Том уурын зуух төхөөрөмж	1984-05-26	1	3,282,928.00	3,282,928.00
9	Санхүү программ	2007-01-01	1	390,000.00	390,000.00
			11	6,666,411.03	8,031,411.03
	ДҮН				(найман сая гучин нэгэн мянга дөрвөн зуун арван нэгэн төгрөг гурван мөнгө)